



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/430

Цагаан-Уул сум

ГҮнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 онд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж хийгдэх Цагаан-Уул сумын халуун усны барилгын их засвар, тохижилтын ажлын даалгавар боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ахлагч: У.Аварзэд (Засаг даргын орлогч)

Гишүүд: А.Хишигбаяр (Төрийн сангийн мэргэжилтэн)

З.Аззаяа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

О.Дашбямба (Галт дулаан ХХК-ны дарга)

Нарийн бичгийн дарга: Ж.Баяржаргал (Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтан)

2. Ажлын даалгавар боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, захиалагчид танилцуулж ажиллахыг үнэлгээний хорооны ахлагч (У.Аварзэд)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэцэцэг)-т даалгасугай.

ДАРГА  С.ГОНЧИГНЯМ



/Zahiramj 2024/